

БАЯЖУУЛСАН ХҮНС БОЛОХЫГ ИЛЭРХИЙЛСЭН ТЭМДЭГ,  
ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ЗАГВАР, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, хэрэглэх, загвар хэмжээг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад орсон хүнсний бүтээгдэхүүнд энэхүү журам хамаарна.

Хоёр. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг,  
тэмдэглэгээний загвар

2.1. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг нь Баяжуулсан хүнсний тухай хуулийн 6.3.3-д заасны дагуу баталсан загвар, хэмжээ, төрөлтэй байна.

Гурав. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг,  
тэмдэглэгээг хэрэглэхэд тавигдах шаардлага

3.1. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүртгэгдсэн байна.

3.2. Аж ахуйн нэгжийн албан хүсэлтийг үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 7 хоногт багтаан бүтээгдэхүүнд баяжуулсан хүнсний лого олгох эсэхийг шийдвэрлэнэ.

3.3. Бүртгэх шийдвэр гарсан өдрөөс эхлэн баяжуулсан хүнсний үйлдвэрлэл эрхлэгч нь бүтээгдэхүүний шошгод баяжуулсан болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэнэ.

3.4. Албан журмаар баяжуулсан хүнс үйлвэрлэгч нь *Зураг1* бүхий логог хэрэглэнэ.



*Зураг1.*

3.7. Албан журмаар баяжуулсан хүнс үйлдвэрлэгч нь *Зураг 1* бүхий лого-г сав баглаа боодлын зүүн дээд буланд байрлуулна.

3.8. Шошгоны орцын хэсэгт “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 12 дахь хэсэгт заасны дагуу мэдээлэх бөгөөд баяжуулагч бэлдмэлийн орц найрлагыг бичнэ.

3.9. Баяжуулсан хүнс тэмдгийг бүтээгдэхүүний савлагааны хэмжээнээс хамааруулан томруулах буюу багасган хэрэглэж болно.

3.10. Шошгоны нүүр хэсэгт, бүтээгдэхүүний оноосон нэрийн өмнө баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, “Баяжуулсан” гэсэн мэдэгдэл хэрэглэхийг хориглох бөгөөд бүтээгдэхүүний оноосон нэрний доод хэсэгт “Баяжуулсан хүнс” мэдэгдлийг ашиглаж болно.

3.11. Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS CAS 1:2007 стандартад заасны дагуу байна.